

REDPATH



# REDPATH КОМПАНИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ



# АГУУЛГА

<b>1</b>	<b>Гүйцэтгэх захирлын Комплайнсын тухай мэдэгдэл</b>	<b>3</b>
<b>2</b>	<b>Бидний амжилтад хүрэх философи ба удирдамж</b>	<b>4</b>
<b>3</b>	<b>Ёс зүйн үндсэн бүлгүүд</b>	<b>5</b>
<b>4</b>	<b>Комплайнсын удирдамж, бусад дүрэм, бодлого</b>	<b>5</b>
<b>5</b>	<b>Үл тэвчих бодлого</b>	<b>6</b>
<b>6</b>	<b>Шударга ёс</b>	<b>6</b>
6.1	Зохисгүй төлбөр	6
6.2	Бэлэг, зугаа цэнгэл	6
6.3	Ашиг сонирхлын зөрчил	6
6.4	Мөнгө угаахтай тэмцэх	7
6.5	Хуулийг сахин дээдлэх	7
<b>7</b>	<b>Redpath компанид ажиллах нь</b>	<b>8</b>
7.1	Ажлын байран дахь харилцаа, бусад үүрэг хариуцлага	8
7.2	Оюуны өмч ба нууц - Эрх бүхий мэдээлэл	9
7.3	Хамтын ажиллагаа ба зөрчлийг мэдээлэх	10
7.4	Өш хонзон авахгүй байх	11
<b>8</b>	<b>Группийн үүрэг хариуцлага</b>	<b>11</b>
8.1	Засгийн газар болон улс төртэй харилцах	11
8.2	Шударга өрсөлдөөн	11
8.3	Санхүүгийн бүртгэл	12
8.4	Redpath компанийн түншүүд	12

# 1. ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН КОМПЛАЙНСЫН ТУХАЙ МЭДЭГДЭЛ

Redpath компанийн хувьд бид байгууллагынхаа үйл ажиллагаанд өндөр ёс зүйн хүлээлт тавьдаг. Манай компанийн зан төлөв бол нийт ажиллагсдын зан төлөвийн нийлбэр бөгөөд хүн бүр хэрхэн ажиллаж, биеэ авч явах ёстойг тодорхойлсон баримт бичигтэй байх нь чухал юм. Энэхүү баримт бичиг бол манай Ёс зүйн дүрэм юм.

**“ Бид гагцхүү ёс зүй, шударга ёсыг дээдэлж ажилласнаар Redpath компанид урт хугацааны тогтвортой үнэ цэнийг бий болгож чадна.**

Бид бүх ажилтан, харилцагч, ханган нийлүүлэгч, бизнесийн хамтрагч байгууллагатайгаа харьцахдаа ёс зүйтэй ажиллах үүрэг хүлээдэг. Бид гагцхүү ёс зүй, шударга ёсыг дээдэлж ажилласнаар Redpath компанид урт хугацааны тогтвортой үнэ цэнийг бий болгож чадна.

Ёс зүйн дүрэм бидэнд тулгарч болзошгүй бүх нөхцөл байдлыг хамрах зорилготой биш,

харин бидний үйл ажиллагаанд ёс суртахууны чиглүүлэгч луужин байх зорилготой юм. Энэхүү дүрэмд тус компанийн үнэ зүйлсийг тусган боловсруулсан бөгөөд бид бүгд дүрмийн үгчилсэн утгыг төдийгүй үзэл санааг мөн дагаж мөрдөх ёстой. Бид дэлхийн хэмжээний компани болохыг зорьдог бөгөөд ийм байгууллагын үндэс суурь нь шударга ёсны соёл байдаг. Манай олон харилцагч Redpath компанийг хариуцлагатай, ёс зүйтэй, бусдыг хүндэтгэдэг гэдгийг мэддэг учраас бидэнтэй хамтран ажилладаг билээ.

Redpath компанийн комплаинс, ёс зүйг тууштай дэмжиж, бидний үнэт зүйлсийг хэрэгжүүлэх хариуцлагыг ухамсарлан, 1962 оноос хойш дэлхий даяар бизнес эрхлэх явцдаа бий болгосон компанийн нэр хүндийг хамгаалж, улам бэхжүүлж байгаад тань баярлалаа.

Хүндэтгэсэн,

*George Flumerfelt*

Гүйцэтгэл захирал  
Redpath Групп Компани



## 2. БИДНИЙ АМЖИЛТАД ХҮРЭХ ФИЛОСОФИ БА УДИРДАМЖ

Redpath компанийн үүсгэн байгуулагч Жим Редпат тус байгууллагыг үүсгэн байгуулах эхэн үе шатанд компанийн философиог тодорхойлсон билээ. Энэхүү философиог дагуу ажилтан бүрийн гол анхаарал харилцагч нартаа чанартай ажил үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн байх ёстой гэж үздэг.

Өнөөдөр ч энэ үндсэн зарчим ажлын бүх талбар, байгууллагын харилцаанд оршсон хэвээр байна. Бүх төслийг нарийн хянаж, аливаа шийдвэр, үйл ажиллагаа тус компанийн үнэт зүйлстэй нийцэж байгаа эсэхийг харгалзан үздэг.

### БИДНИЙ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ



Редпат группийн баримталдаг үүрэг бол:

Ердийн буюу хүлээн зөвшөөрөгддөг стандартаас өндөр хэмжээний үйлчилгээг салбартаа үзүүлэх;

Салбарт бидний үйлчилгээг үргэлжлүүлэн авах хүсэл сонирхлыг бий болгох;

Өөрийн ажилтнуудаа гүйцэтгэх ажилтай бас сорилттой байлгах;

Салбартаа үйлчилгээний өндөр чанар, тогтвортой өсөлтийг баримтлах;

Бид 1962 оноос эхлэн энэхүү үзэл баримтлалаар явж ирсэн бөгөөд хойшид ч итгэлтэйгээр баримтлан ажиллах болно;

**“Сорилт бол амьдралын чухал хэсэг юм.”**



**REDPATH MONGOLIA LLC**  
Mining Contractors and Engineers

[redpathmining.com](http://redpathmining.com)

### АМЖИЛТАНД ХҮРЭХ УДИРДАМЖ



Бид үнэнч, шударга, хариуцлагатай.

Бид боломжит хамгийн сайн гүйцэтгэлийг алдаагүй хийхийн тулд төлөвлөгөө, төсвийг үнэн зөв гаргадаг.

Бидний ажлын зарчим  
**“Аюулгүй байдал – Эхэнд,  
Төгсгөлд, бас Үргэлж.”**

Бид хэзээ ч өрсөлдөөнийг шүүмжилдэггүй.

Бид техникийн баримт бичгийг бүрэн боловсруулдаг.

Бид боломжоос хэтэрсэн үүрэг амлалт авдаггүй.

Бид хэрэв хариултыг нь мэдэхгүй бол асуудаг.

Бид захиалагчиддаа хамгийн сайн үйлчилгээ үзүүлэх зорилтоо мартдаггүй. Шалтаг тоочих нь хүлээн зөвшөөршгүй асуудал.

Бид өөрсдийн болон захиалагчдынхаа урт хугацааны ашиг сонирхлын төлөө ажилладаг.

Бид богино хугацааны ашигтай нөхцлийг давуу тал гэж үздэггүй.

[redpathmining.com](http://redpathmining.com)

### 3. ЁС ЗҮЙН ҮНДСЭН БҮЛГҮҮД



### 4. КОМПЛАЙНСЫН УДИРДАМЖ БА БУСАД ДҮРЭМ, БОДЛОГО



Энэхүү Ёс зүйн дүрэмд заасан зарчмууд нь ерөнхий чиглэлтэй. Эдгээрийг хэрхэн зөв хэрэгжүүлэх талаар нэмэлт заавар авах шаардлагатай бол Redpath компани бүх ажилтанд нээлттэй Комплайнсын хөтөлбөрийг санал болгодог. Үүнд дэлхийн хэмжээний комплайнсын ажилтнуудын сүлжээнд шууд хандах боломж багтдаг бөгөөд тэд Ёс зүйн дүрэмтэй холбоотой аливаа асуултад хариулж, дэмжлэг үзүүлдэг. Мөн ажилтнууд байнгын сургалтад хамрагдаж, тус группийн комплайнсын цогц удирдамжид хандах боломжтой. Энэ удирдамж Ёс зүйн дүрмийг ойлгох, дагаж мөрдөхийн зэрэгцээ ойлголтоо бэхжүүлж, хариуцлагатай байдлаа хангахад туслах зорилготой юм.

## 5. ҮЛ ТЭВЧИХ БОДЛОГО

Redpath компани энэхүү Ёс зүйн дүрэмд заасан бүх зарчмын хүрээнд дэлхий хэмжээнд үл тэвчих бодлогыг хэрэгжүүлдэг. Ёс зүйн зөрчлийн талаарх сэжигтэй эсвэл батлагдсан мэдээллийг удирдлага эсвэл комплайнсын баг нягтлан шалгана. Хэрэв зөрчил батлагдвал зохих сахилгын арга хэмжээ авна. Шийтгэл нь зөрчлийн ноцтой байдлаас хамаарч, шаардлагатай тохиолдолд ажлаас чөлөөлөх, гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авах боломжтой.

## 6. ШУДАРГА БАЙДАЛ

### 6.1 Зохисгүй төлбөр

Redpath компанийн үнэнч, шударга байдлыг эрхэмлэгч гэсэн нэр хүндийг хэзээ ч зохисгүй төлбөрийг санал болгосноор унагааж болохгүй. Төрийн албан тушаалтнууд, улс төрийн намууд болон тэдгээрийн төлөөлөгчид, хувийн хэвшлийн хүмүүс болон ажилтнуудтай харилцахдаа бизнес олж авах, хадгалах, эсвэл зохисгүй ашиг олох зорилгоор шууд болон шууд бусаар аливаа санхүүгийн эсвэл бусад давуу байдлыг санал болгох, амлах, олгохыг хориглоно.

### 6.2 Бэлэг сэлт, зугаа цэнгэл

Бизнесийн үйл ажиллагааны явцад аливаа этгээдээс бэлэг сэлт, зугаа цэнгэл, төлбөр мөнгө авах, өгөх, зардал гаргах нь бидний нэр хүндэд сөргөөр нөлөөлж, Redpath компанийн шийдвэр гаргалтад шударга бус нөлөө үзүүлсэн гэх хардлагыг төрүүлж болзошгүй. Иймд бизнесийн шийдвэрт нөлөөлж болзошгүй гэж үзэж болох, эсвэл хууль, дүрэм, комплайнсын шаардлагыг зөрчих аливаа ашиг тусыг өгөх, авах, хүлээн зөвшөөрөхийг ажилтнуудад хориглоно.

### 6.3 Ашиг сонирхлын зөрчил

Хувийн ашиг сонирхол компанийн ашиг сонирхолтой зөрчилдөх үед ашиг сонирхлын зөрчил үүсэж болно. Бид ийм нөхцөл байдлыг ойлгож, шаардлагатай арга хэмжээг авч чадвал урьдчилан сэргийлэх боломжтой. Ерөнхийдөө хувийн ашиг сонирхол, байгууллагаас гадуурх үйл ажиллагаа, санхүүгийн сонирхол эсвэл харилцаа холбоо нь Redpath компанийн ашиг сонирхолтой зөрчилдөх эсвэл зөрчилдөж байгаа



мэт харагдах нөхцөлөөс зайлсхийх хэрэгтэй бөгөөд компанийн нэрийн өмнөөс явуулж буй бизнесийн үйл ажиллагаанд хувийн ашиг сонирхол, харилцаа нөлөөлөхийг зөвшөөрөх ёсгүй.

Ашиг сонирхлын зөрчлийн хамгийн түгээмэл хэлбэр бол ажилтан бизнесийн гэрээ байгуулах, ажилтан сонгон шалгаруулах, санхүүгийн зах зээлд сонирхол татахуйц мэдээлэлд нэвтрэх эрхтэй байх, эсвэл өрсөлдөгч компаниас ажлын санал авах зэрэг нөхцөл байдал юм. Ашиг сонирхлын зөрчлийн зарим жишээг дор дурдав.

**Гадуурх ажил эрхлэлт:** Redpath компанид эрхэлдэг ажилтай төстэй, гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж болзошгүй ажил эрхлэх, эсвэл Redpath компанийн бодит болон боломжит өрсөлдөгч, ханган нийлүүлэгч, харилцагчидтай хамтран ажиллах.

**Гэр бүлийн гишүүд болон хувийн дотно харилцаа:** Гэр бүлийн гишүүн, эсвэл гэрлээгүй хамтрагч болон тэдний удирддаг, эзэмшдэг компанитай гэрээ байгуулах.

**Хөрөнгө оруулалт:** Redpath компанийн

худалдан авах сонирхолтой байж болох үл хөдлөх хөрөнгө, компаниудад хувь эзэмших.

**Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнчлэл:** Далд уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг, эсвэл Redpath компанитай холбоотой аливаа байгууллагад (жишээлбэл, түнш, ханган нийлүүлэгч, харилцагч) албан тушаалтан, зөвлөх, эсвэл захирлаар ажиллах, эсвэл ийм албан тушаалыг хүлээн авах.

**Их хэмжээний эзэмшил:** Redpath компанитай бизнес хийх эсвэл хийхээр зорьж буй, эсвэл өрсөлдөгч компаниудад тодорхой хэмжээний хувь эзэмших.

Ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй гэж үзэж буй ажилтан өөрийн шууд удирдлага эсвэл хүний нөөцийн төлөөлөгчид нэн даруй мэдэгдэх ёстой. Тус группийн холбогдох комплайнсын ажилтан нөхцөл байдлыг үнэлж, хэрэв зөрчил илэрвэл ккомплайнсын удирдамжид нийцүүлэн авах арга хэмжээний талаар зөвлөгөө өгнө.

## 6.4 Мөнгө угаахтай тэмцэх

Redpath компанийн шударга байдал, үнэнч байдал, ил тод байдлыг эрхэмлэдэг амлалт нь үйл ажиллагаа явуулж буй бүх улс оронд мөнгө угаахтай тэмцэх хууль тогтоомжийг бүрэн дагаж мөрдөх үүрэгтэй.

Мөнгө угаах гэдэг нь хууль бус эх үүсвэртэй хөрөнгийг хууль ёсны санхүүгийн системд оруулж, түүний гарал үүслийг нуун дарагдуулах эсвэл хууль ёсны мэт харагдуулах үйл явц юм.

Ажилтнууд Redpath компанийн шударга байдал, нэр хүндийг хамгаалахын тулд мөнгө угаахтай холбоотой үйл ажиллагааг илрүүлэхэд анхаарал хандуулах ёстой. Үүнд хэрэглэгчид бүрэн мэдээлэл өгөхөөс татгалзах, эсвэл бэлэн мөнгөөр төлбөр хийхийг хүсэх зэрэг анхааруулах шинж тэмдгүүд багтаж болно.

## 6.5 Хуулийг сахин дээдлэх

Redpath компанийн шударга, ёс зүйтэй компани гэсэн нэр хүндийг хадгалах нь компани, ажилтнууд хуулийг чанд мөрдөхөөс эхэлнэ. Иймээс бүх ажилтан өөрийн албан үүрэгтэй холбоотой хууль эрх зүйн болон зохицуулалтын шаардлагыг дагаж мөрдөх ёстой бөгөөд удирдлага нь шаардлагатай удирдамж, дэмжлэгийг үзүүлэх үүрэгтэй.

Жишээлбэл, Redpath компани ялгаварлан гадуурхахгүй байх, хөдөлмөрийн шударга стандартыг мөрдөх, ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад тууштай анхаардаг. Ажилтнууд эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчныг хамгаалахтай холбоотой бүх хууль, дүрэм журмыг мөрдөж, шаардлагатай лиценз, зөвшөөрлийг авах ёстой.

Redpath компани ажилтнуудаас эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчныг хамгаалах зорилготой бүх хууль тогтоомжийг дагаж мөрдөх, шаардлагатай бүх зөвшөөрлийг авах, үйл ажиллагаагаа холбогдох хууль тогтоомжийн дагуу чанд явуулахыг шаарддаг.

Redpath компанийн үйл ажиллагаа явуулж буй орчны хууль эрх зүйн болон зохицуулалтын нөхцөл байдал нь нарийн төвөгтэй тул заримдаа хууль мөрдөлттэй холбоотой асуудлууд үүсэж болзошгүй байдаг. Компанийн эрх зүйн байдалтай холбоотой маргаан гарч, шүүхийн хэрэг үүсэх боломжтой. Ийм тохиолдолд тус компани хариуцлагатай хандаж, шүүхийн эцсийн шийдвэрийг дагаж мөрдөнө. Мөн төрийн байгууллагуудаас асуулга, шалгалт ирэх тохиолдол гарч болно.

Төрийн байгууллагын шаардлагыг хангахтай холбоотой асуудлууд ч үүсэж болзошгүй. Ийм асуудлыг эрт үед нь Redpath компанийн удирдлагад мэдээлэх нь чухал.

Комплайнстай холбоотой бодит эсвэл сэжигтэй асуудлын талаар удирдлагад шуурхай мэдээлэх нь маш чухал. Ажилтнууд хууль эрх зүйн болон зохицуулалтын эрсдэл байж болзошгүй аливаа шинж тэмдгийг нэн даруй мэдээлэх үүрэгтэй бөгөөд ингэснээр шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авах боломж бүрдэнэ.




## 7. REDPATH КОМПАНИД АЖИЛЛАХ НЬ

### 7.1 Ажлын байранд дахь харилцаа болон ажлын байран дахь бусад үүрэг хариуцлага

Redpath компани олон талт байдлыг давуу тал гэж үздэг. Дэлхийн олон орны янз бүрийн бизнес жил ирэх тусам Redpath компанийн дор нэгдэн ажиллах болсон бөгөөд тус компанийн соёл нь хүйс, үндэс угсаа, нас, бие бялдрын чадвар болон бусад аливаа ялгаанаас үл хамааран хүн бүрийг хүлээн зөвшөөрдөг. Ажилтнууд хамтран ажиллагчид, харилцагчид, оролцогч талууд болон бизнесийн түншүүдтэй харилцахдаа ялгаатай эсвэл төстэй байдлаас үл хамааран бүх хүнийг хүндэтгэн ажиллах ёстой.

Redpath компани ажилд авах, албан тушаал дэвшүүлэх шийдвэрийг зөвхөн тухайн хүний чадвар, гүйцэтгэлд үндэслэн гаргадаг. Ажилтнуудыг ажилд авах, цалин хөлс олгох,

сургалтад хамруулах, албан тушаал дэвшүүлэх, ажлаас халах эсвэл тэтгэвэрт гаргах зэрэгт хүйс, нас, үндэс угсаа, гарал үүсэл, нийгмийн давхарга, шашин шүтлэг, хөгжлийн бэрхшээл, бэлгийн чиг баримжаа, үйлдвэрчний эвлэлийн гишүүнчлэл, улс төрийн хамаарал зэргээр ялгаварлан гадуурхах, эсвэл тийм үйлдлийг дэмжих ёсгүй.



#### Ажлын байрны аюулгүй байдал

**Аюулгүй ажлын байр гэдэг нь хүн бүртэй хүндэтгэлтэй харьцаж, бие махбодын болон сэтгэл зүйн аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьдаг орчныг бүрдүүлэхийг хэлнэ. Энэхүү стандарт нь зөвхөн ажлын байранд төдийгүй компанийн бизнес, ажлын холбогдолтой үйл ажиллагаа эсвэл нийгмийн арга хэмжээ явагдаж буй бүх орчинд хамаарна.**

Дарамт, бэлгийн дарамт, дээрэлхэлт, заналхийлэл, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт болон бусад хууль бус үйлдлийг манай “Ажлын байрны харилцааны комплайнсын удирдамж”-д тодорхой заасан бөгөөд эдгээрийг ямар ч нөхцөлд тэвчихгүй. Redpath компани эдгээр үйлдлийг аюулгүй байдлын асуудал гэж үзэж, эрүүл мэнд, аюулгүй байдлын бодлоготой уялдуулан бүртгэж, хяналт тавьдаг бөгөөд аливаа асуудлыг удирдлагад шуурхай мэдээлэхийг шаарддаг.

Ийм үйлдэл гаргасан ажилтан нь холбогдох хөдөлмөрийн хууль, хөдөлмөрийн гэрээ, Redpath компанийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөнд тооцож, зохих сахилгын арга хэмжээ авах болно.

#### Олон талт байдал, тэгш байдал ба хүртээмж

Дэлхийн таван тив, олон улс оронд үйл ажиллагаа явуулдаг олон улсын компанийн хувьд бид ажилтнуудынхаа олон талт байдал, гарал үүслийг өндөр үнэлж, хүндэтгэдэг. Бид бүх ажилтанд зориулсан олон талт байдал, хүртээмжтэй, тэгш орчныг идэвхтэй дэмжиж, хөгжүүлэхийг зорьдог.

Олон талт байдал гэдэг нь хүн бүрийн ялгаатай байдал, өвөрмөц чанарыг илэрхийлнэ. Үүнд хувь хүмүүс болон бүлгүүдийн ажлын байранд авчирдаг ур чадвар, мэдлэг, туршлага, үзэл бодлын ялгаа багтана. Мөн нас, удамшил, хүйс, бэлгийн чиг баримжаа, шашин шүтлэг, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн байдал, асран халамжлах үүрэг, жирэмслэлт зэрэг бидний хэн болохыг тодорхойлбог бусад шинж чанарыг хамардаг боловч үүгээр хязгаарлагдахгүй. Эдгээрийн ихэнхийг ялгаварлан гадуурхалтаас хуулиар хамгаалсан байдаг.

Зарим хувийн шинж чанарыг хуулиар хамгаалдаг бөгөөд олон талт байдлыг үнэлнэ гэдэг нь зөвхөн хууль ёсны хамгаалалтаас гадна ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, үнэлж буй илүү өргөн ойлголт юм.

Ажлын байрны тэгш байдал гэдэг нь бүх ажилтанд шударга боломж, ахиц дэвшилд хүрэх нөхцөлийг бүрдүүлэхийг хэлнэ.

Өөрөөр хэлбэл, хүн бүр гарал үүсэл, нөхцөл байдлаасаа үл хамааран бүрэн хөгжиж, хувь нэмрээ оруулах боломжтой шударга орчныг бий болгохыг зорьдог. Харин оролцоо гэдэг нь хүн бүр өөрийг нь анзаарсан, сонссон, үнэлсэн гэж мэдрэх ажлын орчныг бүрдүүлэх явдал юм. Redpath компани хүртээмжтэй, олон талт байдлын төлөөлөл болсон баг хамт олон нь илүү хамтын ажиллагаатай байхаас гадна ажлын орчны эерэг уур амьсгалыг бүрдүүлж, нийт гүйцэтгэлийг сайжруулдаг гэдгийг ойлгодог.

### **Бид компанийн хөрөнгийг хамгаалдаг**

Redpath компани нь ажилтнууд, хамтран ажиллагсдаа үр дүнтэй ажиллахад шаардлагатай багаж хэрэгсэл - тоног төхөөрөмж болон мэдээллээр - хангахын тулд бүх боломжийг дайчлан ажиллана. Redpath компанийн биет хөрөнгө, оюуны өмчийн эрх



болон мэдээллийг алдагдах, хулгайд алдах эсвэл гэмтэхээс сэргийлж, болгоомжтойгоор ашиглах ёстой.

Хөрөнгөд байгууллагын бүтэц зохион байгуулалтын схем, технологи болон процессууд, үйлдвэрлэлийн арга барил, мөн маркетинг, сурталчилгаа болон бизнес хөгжлийн судалгаа, төлөвлөгөө зэрэг багтана.

Компанийн бүх хөрөнгийг зөвхөн бизнесийн зорилгоор ашиглана.

### **Манай мэдээллийн системүүд - MC**

Redpath компанийн мэдээллийн систем биднийг

үр ашигтай, мэргэжлийн түвшинд ажиллахад дэмжлэг үзүүлэх зорилготой.

Имэйлээр хийсэн аливаа харилцаа Redpath компанийн албан ёсны мэдэгдэл гэж тооцогдох боломжтойг санах хэрэгтэй. Иймээс ажилтнууд компанид арилжааны хувьд нууц, маргаантай, эсвэл гэрээ болон хууль эрх зүйн сөрөг үр дагавар үүсгэж болзошгүй мэдээллийг задруулах ёсгүй.

Зохиогчийн эрх, гүтгэлэг, ялгаварлан гадуурхалт болон бичгээр харилцах бусад хэлбэрийг зохицуулсан хууль дүрэм онлайн болон имэйл харилцаанд мөн адил үйлчилнэ. Зөвшөөрөлгүй эсвэл лицензгүй программ хангамжийг Redpath компанийн мэдээллийн системд суулгахыг хориглоно.

Redpath компанийн мэдээллийн системийг компанийн болон гуравдагч этгээдийн сүлжээ, өгөгдлийн бүрэн бүтэн байдалд халдах зорилгоор ашиглахыг хориглоно. Үүнд гинжин захидал тараах эсвэл хүсээгүй сурталчилгааны имэйл (spam) илгээх, дамжуулах үйлдлүүд багтана.

Redpath компанийн мэдээллийн систем дээр үүсэж, хадгалсан бүх мэдээллийг компанийн өмч гэж үзэх бөгөөд хууль эсвэл гэрээгээр хязгаарласан тохиолдлоос бусад үед Redpath компани энэ мэдээлэлд нэвтрэх эрхтэй байна. Ажилтнууд өөрсдийн цахим файл, архивыг эмх цэгцтэй хадгалах үүрэгтэй.

## **7.2 Оюуны өмч ба нууц - Эрх бүхий мэдээлэл**

### **Оюуны өмч**

Redpath компанитай хамтын ажиллагааны явцад бий болсон эсвэл өөрчилсөн зохиогчийн эрх, барааны тэмдэг, дизайн, шинэ бүтээл, сайжруулалт, нээлт болон бусад аливаа хэлбэрийн оюуны өмч (жишээлбэл протокол, журам, техникийн процесс, судалгааны аргачлал гэх мэт) нь зөвхөн Redpath компанийн өмч хэвээр үлдэнэ.

Үүнээс гадна Redpath компанитай холбоотой харилцааны явцад олж авсан нууц мэдээллийн үндсэн дээр гадуур хөгжүүлсэн аливаа оюуны өмч мөн Redpath компанид хамаарна. Ийм тохиолдолд Redpath компанийн өмчлөлийг баталгаажуулах баримт бичигт гарын үсэг зурах шаардлагатай байж болно.

## Нууц мэдээлэл

Ажилтан, харилцагч, туслан гүйцэтгэгч эсвэл ханган нийлүүлэгч зэрэг бүх талын хувийн мэдээллийн нууцыг үргэлж хүндэтгэх ёстой. Ажилтнууд хувийн мэдээллийг цуглуулах, ашиглах, хадгалах, боловсруулах болон задруулахдаа Redpath компанийн нууцлалын бодлого, холбогдох хууль тогтоомжийг чанд мөрдөх үүрэгтэй. Гэвч Redpath компанийн байгууламжаар дамжуулан хийсэн харилцаанд ажилтнууд тухайн харилцаанд хууль тогтоомжоор тогтоосон хэмжээнээс давсан нэмэлт нууцлалын эрх шаардах боломжгүй. Орон нутгийн хууль тогтоомжийн хүрээнд Redpath компани имэйл болон интернетийн ашиглалтыг хянах эрхтэй.

Redpath компанийн байгууламжаар дамжуулан хийсэн бүх имэйл болон интернет харилцааг компанийн бизнесийн мэдээлэл гэж тооцдог бөгөөд Redpath шаардлагатай тохиолдолд тэдгээрт нэвтрэх, сэргээх, хянах болон задруулах эрхтэй.

## Эрх бүхий мэдээлэл

Redpath компанитай хамтын ажиллагааны явцад олон нийтэд хараахан ил болоогүй, хэрэв нийтэд ил болсон тохиолдолд манай үйлчлүүлэгчид, ханган нийлүүлэгчид эсвэл хамтарсан хөрөнгө оруулагчдын үнэт цаас, дериватив (жишээлбэл хувьцааны эрх гэх мэт)—ийн үнэд нөлөөлж болзошгүй “дотоод мэдээлэл”-тэй тулгарч болзошгүй.


Дотоод мэдээлэлд олон нийтэд нээлттэй бус санхүүгийн мэдээлэл, борлуулалт ба ашиг орлогын тоо баримт, ногдол ашиг өөрчлөх төлөвлөгөө, шинэ санхүүжилт, худалдан авалт, томоохон шинэ гэрээ болон бусад санхүүгийн асуудал багтаж болно.

Ийм төрлийн дотоод мэдээлэлтэй холбоотойгоор тухайн мэдээллийг эзэмшиж буй бүх ажилтанд дараахыг анхааруулна: үнэт цаас эсвэл дериватив арилжаанд оролцох нь зөвхөн манай дүрмээр хориглогдоод зогсохгүй, ихэнх улс оронд хууль бус үйлдэл юм. Мөн бид ийм дотоод мэдээлэлтэй бол тухайн компаниудын үнэт цаас эсвэл деривативыг худалдах, худалдан авахыг бусдад зөвлөхийг хатуу хориглоно.

Үүнээс гадна Redpath компани эсвэл үйлчлүүлэгчийн зүгээс сонирхож болзошгүй

хөрөнгө (жишээлбэл үл хөдлөх хөрөнгө)-ийг урьдчилан мэдэж байгаа тохиолдолд түүнийг худалдан авахыг хориглоно. Мөн ийм мэдээллийг ашиглан ойролцоох үл хөдлөх хөрөнгийг таамгаар эсвэл хөрөнгө оруулалтын зорилгоор худалдан авахыг Гүйцэтгэх захирал болон Комплайнсын захирлын урьдчилсан зөвшөөрөлгүйгээр хийхийг хориглоно.

Бид бүгд дотоод мэдээллийг гуравдагч этгээдэд задруулахгүй байх үүрэгтэй. Үүнд харилцагч, зөвлөх, гэр бүл, найз нөхөд, санхүүгийн шинжээч, сэтгүүлчид багтана. Ийм мэдээлэл нь зөвхөн эрх бүхий этгээдийн хүрээнд үлдэх ёстой. Дотоод мэдээлэл болон дотоод арилжаатай холбоотой зөв зөвлөгөө, журмын талаар



Гүйцэтгэх захирал, Санхүүгийн болон Комплайнсын захирлуудаас мэдээлэл авах боломжтой.

## 7.3 Хамтын ажиллагаа ба буруутгал

Орон нутгийн хууль тогтоомжийн дагуу бид бүгд энэхүү Ёс зүйн дүрэм, мөн хууль, дүрэм, журам, дотоод бодлого эсвэл ёс зүйн стандартыг зөрчсөн эсвэл зөрчсөн байж болзошгүй аливаа үйлдлийг сайн санааны үндсэн дээр хамтран ажиллаж, мэдээлэх үүрэгтэй. Энэ нь манай бизнесийн бүлэг, үйл ажиллагааны нэгж эсвэл нийт Redpath компанийн хүрээнд хамаарна. Мэдэгдэж буй эсвэл сэжигтэй зөрчлийг мэдээлээгүй тохиолдолд сахилгын арга хэмжээ авах үндэслэл болж болно.

**Ёс зүйн зөрчлийг дараах мэдээллийн сувгуудын аль нэгээр дамжуулан мэдээлнэ:**

- Таны шууд удирдлага
- Хүний нөөц
- Хүний нөөц, санхүү, хууль эрх зүйн асуудал

- эрхэлсэн байгууллагын холбоо барих хүмүүс
- Комплайнсын ажилтнууд
- Ёс зүй ба комплайнсын шуурхай утас
- Ёс зүй ба комплайнсын вэбсайт

Бид бүгд Redpath компанийн үнэт зүйлс болон энэхүү дүрмийг дагаж мөрдөх үүрэгтэй. Дүрмийн дагуу гаргасан аливаа санаа зовнил, гомдол, мэдээллийг нууцлалтайгаар авч үзэн ямар нэгэн хэлбэрийн дарамт, өшөө авалтаас хамгаална. Орон нутгийн хууль тогтоомжийн дагуу мэдээлэх үүргээ биелүүлээгүй тохиолдолд сахилгын арга хэмжээ авч, ажлаас чөлөөлөх хүртэл арга хэмжээ авах боломжтой.

Redpath компани ирсэн бүх мэдээлэл, гомдлыг үнэн зөв, сайн санааны үндсэн дээр гаргасан гэж үздэг. Хэрэв мэдээлэл хангалттай үндэслэлтэй, бодитой байвал компанийн зүгээс боломжит хугацаанд, зохих нөөцийг ашиглан шалгалт явуулна.

Манай дүрмийн дагуу явуулж буй шалгалтыг дээд зэргийн хүндэтгэл, болгоомж, нууцлалтайгаар хийх бөгөөд хуулиар зөвшөөрсөн хэмжээнд болон бүрэн шалгах шаардлагын хүрээнд нууцыг хадгална.

Гэсэн хэдий ч, хэрэв Redpath компани гэмт хэргийн шинжтэй эсвэл зохисгүй үйл ажиллагааг илрүүлбэл холбогдох эрх бүхий байгууллагад мэдээлэх эрхтэй.

## 7.4 Өш хонзон авахгүй байх

Redpath компанид хууль бус эсвэл ёс зүйгүй үйлдлийн талаар сайн санааны үндсэн дээр санаа зовнил, мэдээлэл гаргасан аливаа ажилтны эсрэг хариу арга хэмжээ авах, дарамт үзүүлэх, эсвэл өшөө авахыг огт хүлээн зөвшөөрөхгүй бөгөөд ийм үйлдэл нь сахилгын арга хэмжээ авах үндэслэл болно.

Мөн мэдээлэх энэхүү процессийг санаатайгаар буруугаар ашиглах аливаа үйлдэлд мөн адил сахилгын арга хэмжээ авна.

# 8. ГРУППИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

## 8.1 Засгийн газар болон улс төртэй харилцах харилцаа

Redpath компани олон улс оронд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд үндэсний болон орон нутгийн засгийн газруудтай харилцахдаа бат бөх, хүндэтгэлтэй харилцааг хадгалахыг чухалчилдаг. Дэлхий даяар төрийн байгууллагууд нь олон нийтийн эрх ашгийг хамгаалах зорилгоор тусгай худалдан авалтын хууль, журам мөрддөг. Эдгээр хууль нь ихэвчлэн албан тушаалтнуудад аливаа ашиг тус санал болгохыг хориглодог бөгөөд мөн одоо ажиллаж буй эсвэл саяхан тэтгэвэрт гарсан төрийн албан хаагчдыг ажилд авахыг хязгаарладаг.

Redpath компанийн ажилтнууд төрийн албан тушаалтнуудтай харилцахдаа үнэн зөв, шударга мэдээлэл өгөх үүрэгтэй бөгөөд төрийн төлөөлөгчидтэй бизнес хийхдээ хамгийн өндөр ёс зүйн стандартыг баримтлах ёстой.

Төрийн байгууллагатай харилцахдаа ажилтнууд холбогдох хууль, дүрэм журмыг мэдэж, дагаж мөрдөх үүрэгтэй бөгөөд тухайн ажил үүргийнхээ хүрээнээс гадуур компанийн нэрийн өмнөөс төрийн албан тушаалтантай шууд харилцахыг хориглоно.

Ажилтнууд өөрсдийн хувийн цаг, мөнгө, нөөцөөр улс төрийн нэр дэвшигч эсвэл намыг дэмжих эрхтэй боловч ийм үйл ажиллагааг өөрсдийн мэргэжлийн үүргээс тодорхой тусгаарласан байх ёстой. Redpath компанийн хөрөнгө, өмч, үйлчилгээ, нэр хүнд болон дүр төрхийг дэлхийн аль ч улс оронд улс төрийн нэр дэвшигч, нам, төрийн албан тушаалтан эсвэл улс төрийн хороог дэмжих зорилгоор ашиглахыг хатуу хориглоно. Энэ дүрмээс аливаа онцгой тохиолдолд зөвшөөрөл авах шаардлагатай бол Комплайнсын захирлын урьдчилан бичгээр өгсөн зөвшөөрөл заавал шаардлагатай.

## 8.2 Шударга өрсөлдөөн

Redpath компани шударга өрсөлдөөн, чөлөөт зах зээлийн тогтолцоог дэмждэг бөгөөд энэ нь хөдөлмөрч байдал, инновацийг үнэлж урамшуулах нөхцөлийг бүрдүүлдэг гэж үздэг. Хэрэв бид харилцагчдад шударга бус хандвал эсвэл өрсөлдөгчидтэй хууль бус тохиролцоо хийвэл харилцагчдын итгэлийг алдах эрсдэлтэй.

Шударга өрсөлдөөн нь чөлөөт зах зээлийн эдийн засгийн суурь бөгөөд дэлхий даяар өрсөлдөөний хууль, дүрмээр хамгаалагддаг. Улс орон бүрд зарим шаардлага нь өөр байж болох ч Redpath компани дараах үндсэн доод стандартыг

мөрддөг:

### **Бид өрсөлдөгчидтэй дараах төрлийн хэлэлцээрийг хийдэггүй:**

- Үнэ, нөхцөл, эсвэл худалдааны нөхцөлийг тогтоох, хянах
- Ханган нийлүүлэгчидтэй хийх өрсөлдөөнийг хязгаарлах
- Redpath компанийн нийлүүлдэг бараа бүтээгдэхүүний экспорт эсвэл импортын урсгалыг хязгаарлах
- Харилцагч, зах зээл, нутаг дэвсгэр эсвэл үйлдвэрлэлийн хөтөлбөрийг хуваарилах
- Худалдан авагчдын тогтоодог дахин борлуулалтын үнэд нөлөөлөх
- Хуурамч эсвэл зохиомол тендер санал гаргах

Худалдаа болон мэргэжлийн холбоодын уулзалтууд нь өрсөлдөөний хуулийн эрсдэл үүсгэж болзошгүйг анхаарах шаардлагатай.

### **Redpath компанийн ажилтны хувьд та дараах зүйлийг хийх шаардлагатай:**

- Зөвхөн бизнес, шинжлэх ухаан, эсвэл мэргэжлийн зорилготой хууль ёсны холбоо, байгууллагын уулзалтад оролцох
- Уулзалт эхлэхээс өмнө эргэлзээтэй асуудлыг шууд удирдлага эсвэл Redpath компанийн хууль эрх зүй, комплайнсын нэгжтэй



зөвлөлдөх

- Хэрэв уулзалтын үеэр хууль бус эсвэл сэжигтэй үйл ажиллагаа ажиглавал уулзалтаас гарах бөгөөд даруй шууд удирдлага эсвэл комплайнсын нэгжид мэдэгдэх
- Өрсөлдөөний хуультай холбоотой асуулт гарвал Комплайнсын нэгжид хандах

## **8.3 Санхүүгийн бүртгэл**

Хөрөнгө оруулагчид, зээлдүүлэгчид болон бусад талууд Redpath компанийн санхүүгийн бүртгэлтэй холбоотой хууль ёсны сонирхолтой байдаг. Иймээс санхүүгийн бүртгэлийн үнэн зөв байдал тухайн бүртгэлүүдийн нарийвчлал, бүрэн бүтэн байдал болон цаг хугацаандаа хийсэн эсэхээс шууд хамаарна. Redpath компанийн бүх бизнесийн гүйлгээг компанийн нягтлан бодох бүртгэлийн зарчим болон холбогдох шаардлагуудын дагуу бүрэн, үнэн зөвөөр бүртгэх ёстой. Буруу эсвэл залилангийн шинжтэй баримт бичиг, тайлагнал нь хууль бус үйлдэл юм.

## **8.4 Redpath компанийн түншүүд**

Redpath компани бүх зах зээлдээ шударга өрсөлдөөнийг эрхэмлэдэг бөгөөд ханган нийлүүлэгчидтэй ажиллахдаа мөн адил өндөр стандартыг баримталдаг. Хэрэв ажилтан ханган нийлүүлэгч сонгох эсвэл удирдах үйл явцад оролцож байвал бүх шийдвэрийг зөвхөн Redpath компанийн ашиг сонирхолд тулгуурлан гаргах ёстой. Хувийн шалтгаанаар аливаа хүн эсвэл бизнесийг давуу байдалтайгаар сонгох, эсвэл тал тохой татахыг зөвшөөрөхгүй.

Бизнесийн харилцаа нь хэзээ ч хувийн эсвэл гэр бүлийн ашиг сонирхлын нөлөөнд автагдах ёсгүй бөгөөд бараа, үйлчилгээ худалдан авах бүх үйл ажиллагаанд Redpath компанийн дотоод бодлогыг дагаж мөрдөнө. Бид төслийг амжилттай хэрэгжүүлэхэд туслах дэд гүйцэтгэгчдэд найдаж ажилладаг бөгөөд тэдний хувь нэмрийг болон манай харилцагчидтай тогтоосон нэр хүндийг өндрөөр үнэлдэг. Энэхүү нэр хүндийг хамгаалж, бэхжүүлэхийн тулд бид зөвхөн энэ Ёс зүйн дүрэмд заасан зарчимтай нийцсэн зан үйлтэй дэд гүйцэтгэгчидтэй хамтран ажиллана. Хамтарсан үйлдвэр эсвэл стратегийн түншлэл байгуулахдаа бид ижил үзэл баримтлалтай, ёс зүйн бизнесийн зарчмыг

хуваалцдаг хувь хүн болон байгууллагуудтай хамтран ажилладаг. Ийм хамтын ажиллагааны стандарт Redpath компанийн стандарттай нийцсэн байх ёстой.

### Хүний эрхийг хүндэтгэх үүрэг амлалт

Redpath компани хүний эрхийг дэмжиж, хүндэтгэдэг бөгөөд үйл ажиллагаа явуулж буй бүх улс оронд мөрдөгдөж буй хүний эрхийн холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрддөг. Мөн бид Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал зэрэг олон улсын хүний эрхийн зарчмуудад тусгасан үнэт зүйлсийг хүлээн зөвшөөрдөг.

### Боолчлол ба хүний наймаа

Redpath компани аливаа хэлбэрийн боолчлол болон хүний наймаа нь хүний суурь эрхийг ноцтой зөрчсөн үйлдэл гэдгийг хүлээн зөвшөөрдөг. 2022 онд Redpath компани нь НҮБ-ын Бизнес ба Хүний Эрхийн Удирдамж Зарчим (UNGPs)-д үндэслэсэн Хүний Эрхийн Мэдэгдлийг нийтэлж, хүний эрхийг хүндэтгэх компанийн үүргээ дахин баталгаажуулсан.

Redpath компанийн бүх бизнесийн үйл ажиллагаа холбогдох хууль, дүрэм журам болон

хүний эрхийг хамгаалах дотоод үүрэг амлалтыг чанд мөрдөх ёстой бөгөөд ялангуяа орчин үеийн боолчлол болон хүний наймаанаас урьдчилан сэргийлэхэд онцгой анхаарна.

### Бид агент, зөвлөхүүдтэй хамтран ажилладаг

Агент болон зөвлөхүүдэд төлөх шимтгэл, төлбөр нь үзүүлж буй үйлчилгээтэй харьцуулахад зохистой байх ёстой. Ажилтнууд зохисгүй төлбөр гэж үзэж болох шимтгэл, хураамжийг тохиролцоо эсвэл төлөхийг хориглоно.

Зөвлөх, брокер, ивээн тэтгэгч, агент болон бусад зуучлагчтай байгуулсан гэрээг төрийн албан хаагчид эсвэл харилцагч байгууллагын ажилтнуудад хууль бус төлбөр дамжуулах хэрэгсэл болгон ашиглахыг хатуу хориглоно.

Ажилтнууд Ёс зүйн дүрмийг жилд дор хаяж нэг удаа, мөн түүний агуулгатай холбоотой асуулт, эргэлзээ гарсан үед дахин нягтлан уншиж танилцах үүрэгтэй.

Компанийн Комплайнсын нэгж энэхүү Ёс зүйн дүрмийг жил бүр хянаж, хууль тогтоомж, дүрэм журам болон шилдэг практикт нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах үүрэгтэй.



## THE REDPATH GROUP

Mining Contractors and Engineers



[redpathmining.com](http://redpathmining.com)

